

ҮСГ-ын 2007 оны ... сарын ...-ны
өдрийн ... тоот тушаалын хавсралт



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР

БИЗНЕС РЕГИСТРИЙГ БАЙГУУЛЖ, ХӨТЛӨХ аргачлал



БИЗНЕС РЕГИСТР

2007 он

“БИЗНЕС РЕГИСТРИЙГ БАЙГУУЛЖ, ХӨТЛӨХ” АРГАЧЛАЛ

АГУУЛГА

Нийтлэг зүйл

БҮЛЭГ I. БИЗНЕС РЕГИСТРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, БҮТЭЦ

- 1.1 Бизнес регистрийн хамрах хүрээ
- 1.2 Бизнес регистрийн бүтэц
 - 1.2.1 Хуулийн этгээд
 - 1.2.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж
 - 1.2.3 Орон нутгийн нэгж
- 1.3 Статистик нэгжийг байгуулах

БҮЛЭГ II. РЕГИСТРИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- 2.1 Код, дугаар
- 2.2 Үндсэн үзүүлэлтүүд
- 2.3 Ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд

БҮЛЭГ III. БИЗНЕС РЕГИСТРИЙН ХӨТЛӨЛТ

- 3.1 Бизнес регистрийн хөтлөлт

“БИЗНЕС РЕГИСТРИЙГ БАЙГУУЛЖ, ХӨТЛӨХ” АРГАЧЛАЛ

Нийтлэг зүйл

Бизнес регистр гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, хөрөнгө, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ /аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ/, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг агуулсан мэдээллийн сан юм.

Регистрийн хамрах хүрээ, бүтэц, агуулга, бизнес регистрийг байгуулах, хөтлөх, ашиглах, статистик нэгжийг байгуулах зэрэг бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү аргачлалын зорилго оршино. Регистр нь **нэгдүгээрт**, статистикийн тооллого, түүвэр судалгааны хамрах хүрээг тогтоох, **хоёрдугаарт**, бүртгэлийн болон судалгаа явуулах суурь мэдээлэл болж ашиглагдана.

Регистрийн үзүүлэлт нь олон улсын байгууллагаас гаргасан нэгдсэн арга зүйн дагуу тодорхойлогдсон байна. Статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдал, олон улсын түвшинд зэрэгцүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, үйл ажиллагааны талаарх нэгдсэн ойлголт, тодорхойлолтыг баримтална. (ойлголт, тодорхойлолтыг хавсралт 1-д үзүүлэв.)

Регистрийн сан нь аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын сан болон жил тутмын регистрийн сан гэсэн 2 хэлбэртэй байна.

БҮЛЭГ I. БИЗНЕС РЕГИСТРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, БҮТЭЦ

1.1 Бизнес регистрийн хамрах хүрээ

Бизнес регистрт (цаашид регистер гэх) эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүд, түүнчлэн захиргааны бүртгэлтэй хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн бүртгэлийн мэдээллийг хамруулна.

1.2 Бизнес регистрийн бүтэц

Статистик нэгж гэдэг нь албан ёсны статистикийн мэдээ, тайлан гаргаж, статистикийн байгууллагад мэдээлэх чадвартай аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл статистикийн байгууллага нь өөрийн статистик мэдээллийг авч нэгтгэх, харьцуулахын тулд мэдээ авах аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгжийг илрүүлдэг. Тухайн илрүүлсэн нэгж нь статистик нэгж болно.

Олон улсын түвшинд статистик нэгжийг дараах байдлаар авч үздэг Үүнд:


- хуулийн этгээд
- үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж/олон төрлийн үйл ажиллагаатай үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж
- орон нутгийн нэгж/олон төрлийн үйл ажиллагаатай орон нутгийн нэгж

Статистик нэгжийн санг дотор нь үйлдвэрлэл, үйлчилгээний болон орон нутгийн нэгж гэж ангилахаас гадна эрхэлж байгаа үйл ажиллагааных нь тооноос хамааруулж олон төрлийн үйл ажиллагаатай үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, олон төрлийн үйл ажиллагаатай орон нутгийн нэгж гэж ангилна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж гэдэг нь үйл ажиллагаа явуулж байгаа, статистикийн тайлан мэдээ гаргаж, статистикийн байгууллагад мэдээлэх чадвартай аж ахуйн нэгж, байгууллага байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа, бие даасан тайлан тэнцэл гаргадаг нэгжийг статистик нэгжээр бизнес регистрт бүртгэнэ.

Дээр дурьдсан статистик нэгжүүдийн зохицуулсан харилцаа нь дараах хэлбэртэй байна.



1.2.1 Хуулийн этгээд

Орон нутгийн нэгж

“Иргэний тухай” Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйлийн 1-д заасны дагуу “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг **хуулийн этгээд** гэнэ.”

“Компаний тухай” Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хуулийн этгээд нь хараат болон охин компанитай байна. Бизнес регистрт хараат болон охин компани нь өөрөө хуулийн этгээд болно. Хараат болон охин компани нь үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тохиолдолд статистик нэгж болно.

“Компаний тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Компаний салбар, төлөөлөгчийн газар компаний оршин байгаа газраас өөр газар байрлах бөгөөд бизнес регистрт хуулийн этгээдийн салбар нэгжээр бүртгэнэ. Салбар, төлөөлөгчийн газар нь тусдаа статистикийн тайлан мэдээ гаргаж статистикийн байгууллагад өгч чадах бол статистик нэгж /орон нутгийн нэгж, олон үйл ажиллагаат орон нутгийн нэгж/ болно.

1.2.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж

Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж гэдэг нь: “бараа үйлчилгээг үйлдвэрлэдэг зохион байгуулалттай нэгж бөгөөд байгаа нөөцөө хуваарилах зэргээр бие даан шийдвэр гаргах эрхтэй. Үйлдвэр, аж ахуйн газар нэг болон хэд хэдэн салбарт байж нэг ба түүнээс дээш хэд хэдэн үйл ажиллагаа явуулж болно”.

1.2.2.1 Олон үйл ажиллагаат үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж

Олон үйл ажиллагаат үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж нь ЭЗСА-ийн 4 оронгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг, аж ахуйн нэгж, байгууллагын нэг эсвэл хэд хэдэн тасаг, цехийн үйл ажиллагаа байна. Эдгээр нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу тайлан тэнцэл гаргах боломжтой байна.

1.2.3 Орон нутгийн нэгж

Аж ахуйн нэгж, байгууллагыг үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтаас гадна мэдээллийн орхигдол, давхардлаас зайлсхийх зорилгоор газар зүйн байршлаар нь орон нутгийн нэгж болгон ангилна. Орон нутгийн нэгж нь аж ахуйн нэгж, байгууллага өөрөө эсвэл түүний өөр байрлалд байрлаж буй (жишээлбэл, дэлгүүр, үйлдвэр, агуулах, албан контор, уурхай эсвэл өртөө гэх мэт) нэгжүүд юм.


Тодорхой салбар, нэгжүүдэд зохион байгуулалт, санхүүгийн хувьд нэгдмэл биш жижиг нэгжүүд үйлчилгээ үзүүлж байж болно. Жишээлбэл, дээд сургуулийн оюутнуудад үйлчилгээ үзүүлж, тухайн сургуулийн байранд байрладаг, зохион байгуулалт, санхүүгийн хувьд тус сургуульд харъяалагдахгүй жижиг цайны газар, дэлгүүрийн үйл ажиллагаа, худалдаа, зоогийн газар зэрэг аж ахуйн нэгж, байгууллагын салбар нэгж байж болно. Эдгээр нь орон нутгийн нэгж болно.

Хуулийн этгээдийн салбар нэгж нь санхүүгийн тооцоо хийж тайлан, баланс гаргадаг хэдий ч тайлан баланс нь төвдөө нэгтгэгдэн мэдээлдэг тохиолдолд мэдээллийн давхардлыг арилгах үүднээс аж ахуйн нэгж, байгууллагын салбар нэгжийг орон нутгийн нэгжээр бүртгэхгүй. Тухайлбал, банкны салбар нэгж, Монголын цахилгаан холбоо ХК-ий салбар гэх мэт. Харин судалгааны зорилгоос хамаарч шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн этгээдийн салбар нэгжээс тус тусад нь судалгаа авч болно.


1.2.3.1 Олон үйл ажиллагаатай орон нутгийн нэгж

Олон үйл ажиллагаатай орон нутгийн нэгж нь олон үйл ажиллагаат үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийн нэг хэсэг юм. Аж ахуйн нэгж, байгууллага нь нэг буюу хэд хэдэн олон үйл ажиллагааны нэгжтэй байна.

Схем 1. Хуулийн этгээд, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгжийн хамаарал, байршлаар



Схем 2. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгжийн хамаарал, эрхэлж байгаа үйл ажиллагаагаар



Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж нь нэг эсвэл хэд хэдэн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд тэдгээрийн орон нутгийн нэгж нь нэг эсвэл хэд хэдэн үйл ажиллагаа явуулж болно. Жишээ нь, УБТЗ нь өөрөө хуулийн этгээд болох ба статистикийн судалгааг авах судалгааны нэгж болно. УБТЗ нь ачаа тээвэр, зорчигч тээвэр, худалдаа, зочид буудал, зоогийн газар, барилга угсралт, их засвар, клуб, вагон засвар, зам засвар зэрэг үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Иймд төмөр зам нь олон үйл ажиллагаат нэгж болно. Түүнчлэн тэдгээр нь байршлын хувьд орон нутгийн нэгж байх бөгөөд зарим орон нутгийн нэгж нь олон үйл ажиллагаа эрхлэн явуулдаг тул олон үйл ажиллагаат орон нутгийн нэгж болно. Тухайлбал, УБТЗ-ын Барилга, орон сууцны 3 дугаар анги нь барилга угсралт, их засвар, барилгын материалын худалдаа, диско клуб, орон сууцны бохир ус зайлуулах зэрэг үйл ажиллагааг тухайн орон нутгийн нэгж дээр эрхлэн явуулж байна.

1.3 Статистик нэгжийг байгуулах

Бизнес регистрт бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй, тайлан тэнцэл гаргадаг аж ахуйн нэгж, байгууллагад статистик нэгжийн дугаарыг ҮСГ-аас олгож, статистикийн нэгжийн санд бүртгэнэ. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хувьд бизнес регистрийн улирлын мэдээ (БР-1, БР-2)-г үндэслэж статистик нэгжээр бүртгэнэ. Үүнийг жишээн дээр тайлбарлая.

“А” аж ахуйн нэгж нь Улаанбаатар хотод ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд бие даасан тайлан тэнцэл гаргадаг гэж үзье. Энэ тохиолдолд уг аж ахуйн нэгж нь үйлдвэрлэл, үйлчилгээний статистик нэгж болно.

“В” аж ахуйн нэгж нь нүүрсний уурхай, зочид буудал, зоогийн газар, худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг гэж үзье. Худалдаанаас бусад үйл ажиллагаагаараа бие даасан тайлан, баланс гаргадаг. Энэ тохиолдолд нүүрс олборлолт, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа бүрээр нь статистикийн нэгж болгож статистик нэгжийн санд бүртгэнэ.

“С” аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна гэе. Энэ тохиолдолд тухайн “С” аж ахуйн нэгжийг бизнес регистрийн санд бизнес регистрийн улирлын мэдээний үзүүлэлтийн дагуу бүртгэнэ. “С” аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа явуулж эхлэх хугацааг бизнес регистрийн улирлын мэдээгээр тодруулж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн тохиолдолд статистик нэгжээр бүртгэнэ.

Бизнес регистрийн санд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж нь “0” кодоор, үүнээс тайлан тэнцэл гаргадаг нэгж нь “1” гэсэн кодоор бүртгэгдэх бөгөөд энэ тохиолдолд уг нэгж нь статистик нэгж болж шууд /програмын дагуу/ бүртгэгдэнэ.

БҮЛЭГ II. РЕГИСТРИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Регистрийн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын бичлэг нь дараах 4 төрлийн мэдээллийг агуулсан байна. Үүнд:

1. код, дугаар
2. үндсэн үзүүлэлтүүд
3. ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд
4. нэгж хоорондын уялдааг харуулсан үзүүлэлтүүд

Хүснэгт 1. Регистрийн сангийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Хуулийн этгээд нэгж	Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж	Орон нутгийн нэгж
1. Код, дугаар			
<input type="checkbox"/> Ялгах дугаар	1a	3a	2a
<input type="checkbox"/> Нэр, хаяг	1b		2b
<input type="checkbox"/> Хариуцлагын хэлбэр	1f		
2. Үндсэн үзүүлэлтүүд			
<input type="checkbox"/> Үндсэн үйл ажиллагаа		3c	2c
<input type="checkbox"/> Хоёрдогч үйл ажиллагаа		3d	(2d)
<input type="checkbox"/> Туслах үйл ажиллагаа			2k
<input type="checkbox"/> Эдийн засгийн үзүүлэлт			
<input type="checkbox"/> ажиллагчдын тоо		3e	2e
<input type="checkbox"/> борлуулалтын орлого		3h	
<input type="checkbox"/> нийт хөрөнгө		(3i)	
<input type="checkbox"/> Газар зүйн байршил			2h
3.Ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд			
<input type="checkbox"/> Үүсэн байгуулагдсан огноо	1d	3f	2f
<input type="checkbox"/> Татан буугдсан огноо	1e	3g	2g
4. Нэгж хоорондын уялдааг харуулсан үзүүлэлтүүд			
<input type="checkbox"/> Нэгжийн хоорондын хяналт	(1g), (1h)	3b	2j

1. Код, дугаар

1.1 Ялгах дугаар: Регистрийн дугаарыг эрх бүхий бүртгэлийн байгууллага олгож, харин статистик нэгжийн ялгах дугаарыг ҮСГ олгоно. Ялгах дугаар нь зөвхөн статистикийн зорилгод ашиглагдана. Статистик нэгжийн ялгах дугаар нь 9 оронтой 7-ийн модулиар шалгагддаг байхад бүртгэх байгууллагаас хуулийн этгээдэд өгч буй регистрийн дугаар нь 7 оронтой 11-ийн модулиар шалгагддаг дугаар байна.

Хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж эхэлмэгц статистик нэгжээр бүртгэж, ҮСГ-ын бизнес регистр хариуцсан мэргэжилтэн статистик нэгжийн дугаарыг 7-ийн модулиар шалгагдсан дугааруудаас олгоно.

Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжид олгогдох статистик нэгжийн дугаарын эхний 2 орон аймаг, нийслэлийн дугаарыг илтгэнэ. Орон нутгийн нэгжийн

хувьд 4-өөр эхлүүлэн аймгийн дугаарыг харгалзуулан дугаарлана. Үлдсэн 6, 7, 8, 9-өөр эхэлсэн статистик нэгжийн дугаар нь нөөц дугаар байна.

- 1.2 Хуулийн этгээд нэгжийн дугаар-1а:** Хуулийн этгээдийн регистрийн дугаар нь регистрийн сан болон бусад байгууллагад /Үндэсний татварын ерөнхий газар гэх мэт/ адил мөрдөгддөг дугаар байж болно. Бусад байгууллагад хэрэглэгддэг регистрийн дугаарыг хэрэглэх нь тэдгээрийн захиргааны статистик мэдээллийг зэрэгцүүлэх боломжийг олгоно. Гэхдээ, хуулийн этгээдийн регистрийн дугаар нь бизнес регистрийн сангийн ялгах дугаар болж чадахгүй.

Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгжийн ялгах дугаар-3а, 2а: Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгж нь тусгайлсан ялгах дугаартай байна. Статистик нэгжээр бүртгэх үед статистикийн байгууллагаас ялгах дугаарыг олгох бөгөөд татан буугдах хүртэлх хугацаанд уг дугаар хэвээр ашиглагдана.

- 1.3 Нэр, хаяг /харилцах хаяг/:** Хуулийн этгээдийн болон түүний орон нутгийн нэгжийн нэр, хаягийг регистрт бүртгэнэ. Нэгжийн хаяг нь шуудангийн хаяг (шуудангийн хайрцгийн дугаар, шуудангийн салбарын дугаар) болон утас, факс, и-майл, вэб хаяг гэх мэт нэмэлт мэдээллүүдийг агуулсан байна.

1.3.1 Хуулийн этгээдийн нэр, хаяг-1b: Нэр, хаяг (шуудангийн хаягийг оруулаад) зайлшгүй байх бөгөөд нэмэлт үзүүлэлт болгон утас, и-майл, факсын дугаарыг оруулна. Хаяг нь аль болохоор дэлгэрэнгүй хэлбэрээр регистрийн санд бүртгэгдсэн байвал зохино.

1.3.2 Хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бүртгэлийн мэдээллийн хувьд иргэний төрсөн огноо, төрсөн газар нутаг, зарим тохиолдолд регистрийн дугаарыг нэмэлт мэдээлэл болгон ашиглана.

1.3.3 Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийн нэр, хаяг: Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь өөрөө үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж байна. Иймд нэр, хаяг /харилцах хаяг/-ийг дахин тусад нь бүртгэх шаардлагагүй бөгөөд хуулийн этгээдийнхээ нэр, хаягаар бүртгэгдэх боломжтой.

Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж нь газарзүйн байршлын хувьд тодорхой нэг орон зай эзэлж байгаа гэсэн утгаараа өөрөө орон нутгийн нэгж байна.

1.3.4 Орон нутгийн нэгжийн нэр, хаяг-2b: Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж нь хэд хэдэн орон нутгийн нэгжтэй бол тэдгээрийг регистрт орон нутгийн нэгжээр бүртгэнэ. Орон нутгийн нэгжийн оршин байгаа хаяг, байрлал, харилцах хаяг зэрэг мэдээллийг зайлшгүй бүрдүүлж, бүртгэсэн байх шаардлагатай.

Орон нутгийн нэгжийн албан ёсны нэр нь түүнийг удирддаг үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийн нэртэй ерөнхийдөө ижил байдаг боловч өөр төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн нэгж нь өөр нэртэй байж болно. (“бүртгүүлсэн нэр” эсвэл “худалдаа, үйлчилгээний цэгийн нэр”) Иймд орон нутгийн нэгжийн нэрийг регистрт бүртгэх шаардлагатай.

- 1.4 Хариуцлагын хэлбэр:** Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр нь хуулийн этгээдийн хувьд чухал мэдээлэл байна.

Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр-1f: Хуулийн этгээд болон иргэдийн санхүүгийн урсгал орлого, зарлагыг эдийн засгийн сектороор харуулах зорилгоор секторын ангиллаар ангилан харуулах шаардлагатай.

Иймд регистрт байгаа статистик нэгжийг хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэртэй уялдуулан секторын ангиллаар дараах байдлаар ангилна.

Хүснэгт 2. Хариуцлагын хэлбэр, секторын ангиллын хамаарал

Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр	Сектор
1. Хувьцаат компани	S11, S12
2. Хоршоо	S11, S12
3. Хязгаарлагдмал хариуцлагатай компани	S11, S12
4. Төрийн байгууллага	S11, S12, S13
5. Төрийн бус байгууллага	S11, S12, S13, S15
6. Нөхөрлөл	S11, S12, S14
7. Өрхийн аж ахуй	S11, S12, S14

Секторын ангилал:

S11 - санхүүгийн бус байгууллага

S12 - санхүүгийн байгууллага

S13 - засгийн газар

S14 - өрхийн аж ахуй

S15 - өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагууд

1.5 Үндсэн үзүүлэлтүүд: Түүвэр судалгааны хамрах хүрээг тогтооход эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, секторын ангилал, борлуулалтын орлого, ажиллагчдын тоо зэрэг үзүүлэлтүүд голлох үзүүлэлтүүд байна.

1.5.1 Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗҮАСА)-Зс, 2с: Статистик нэгж болох үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгж, тэдгээрийн олон үйл ажиллагаатай нэгжийн эрхэлдэг үйл ажиллагааг тодорхойлох хэмжигдэхүүн нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал байна. Регистрт статистик нэгжийн үйл ажиллагааг ЭЗҮАСА-ын дагуу бүртгэнэ. ЭЗҮАСА нь шинэчлэгдэж болох тул ангилал хооронд хөрвөх боломжийг бүрдүүлсэн байдлаар зохион байгуулна.

Аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн үйл ажиллагааг аж ахуйн нэгжийн хувьд ЭЗҮАСА-ын дагуу явуулж буй үйл ажиллагааг нь ангилж кодолно (үзүүлэлт-2с). Хэрэв нэг аж ахуйн нэгж, байгууллага нэгэн зэрэг олон төрлийн үйл ажиллагаа явуулж байвал үндсэн үйл ажиллагааг нь олон улсын ангиллын дүрэмд заагдсаны дагуу тодорхойлно.

Регистрийн санд үйлдвэрлэл явуулж байгаа үндсэн үйл ажиллагаанаас гадна хоёрдогч болон туслах үйл ажиллагааг тодорхойлж оруулна. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, салбар нэгжийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг олон улсын ЭЗҮАСА -н дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн бизнес регистр хариуцсан мэргэжилтэн кодлож, ҮСГ-н бизнес регистр хариуцсан мэргэжилтэн хянаж, регистрийн санд оруулна.

1.5.1.1 Статистик нэгжийн үндсэн үйл ажиллагааг тодорхойлохын тулд шаталсан бүтэцтэй “ихээс бага руу хуваарилах аргаар” (Top-down method) тодорхойлно. Ингэхдээ **нэгдүгээрт**, ЭЗҮАСА-ын салбарыг тодорхойлохдоо олон үйл

ажиллагаатай нэгжийн нэмэгдэл өртгийн дүнд хамгийн өндөр хувь эзэлж байгаа салбарыг эхлэн сонгоно. **Хоёрдугаарт**, салбар дотроо хамгийн их хувь эзэлж байгаа дэд салбарыг сонгоно. **Гуравдугаарт**, салбар дотор нь хамгийн их хувь эзэлж байгаа ЭЗҮАСА-ын бүлгийн түвшинд, дараа нь дэд бүлгийн түвшинд тус тус сонгоно. Жишээ болгож тайлбарыг Хавсралт 2-т үзүүлэв. Нэмэгдэл өртгийн мэдээллийг ашиглах боломжгүй тохиолдолд борлуулалтын орлого, цалингийн хэмжээ, хөрөнгийн үзүүлэлтийг ашиглан үндсэн үйл ажиллагааг тогтоож болно.

1.5.1.2 Хоёрдогч үйл ажиллагаа: Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээний үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг хоёрдогч үйл ажиллагаа гэж үзнэ. Хоёрдогч үйл ажиллагаа нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны 10-аас дээш хувийг эзэлж байвал хоёрдогч үйл ажиллагаагаар бүртгэнэ. Энэ нь олон үйл ажиллагаатай орон нутгийн нэгжийн хувьд ч адил байна. (үзүүлэлт-3d, 2d).

1.5.1.3 Туслах үйл ажиллагаа-2к: Туслах үйл ажиллагаанд аж ахуйн нэгжийн санхүү, борлуулалт, бичиг хэрэг, тээвэрлэх, савлах, сурталчлах зэрэг туслах үйл ажиллагаанууд хамаарна. Туслах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь үндсэн үйлдвэрлэлд завсрын хэрэглээ болдог бөгөөд салбарын ангилалд бие дааж тусгагдахгүй. Жишээлбэл удирдах газар, байгууллага тусдаа байлаа ч гэсэн тухайн нэгждээ хамаарна.

1.5.2 Эдийн засгийн үзүүлэлт: Статистик нэгжийн цар хүрээг тодорхойлоход ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, хөрөнгө зэрэг олон шалгуур үзүүлэлтүүд байж болно.

1.5.2.1 Ажиллагчдын тоо-3е, 2е: Регистрийн сан нь тухайн аж ахуйн нэгжид байгаа ажиллагчдын бодит тоог бүртгэсэн байна. Ажиллагчдын тооны бүлэглэлтийг тухайн салбарын онцлогоос хамааруулан салбар бүрт тохирсон байдлаар гаргаж болно. Судалгаанд жижиг аж ахуйн нэгжийг сонгох түүвэр хийхдээ нийт ажиллагчдын тоог голлон ашигладаг бол зарим улс оронд цалин, хөлс авдаг ажиллагчдын тоог ашигладаг.

Ажиллагчдын жилийн дундаж тоог тайлант үеэр тооцож авна. Тухайн аж ахуйн нэгж нь жилийн дотор үйл ажиллагаагаа эхэлсэн болон дуусгасан байхыг үл харгалзан түүний ажиллагчдын тоог жилийн турш ажилласан гэж үзнэ. Хэрэв тухайн аж ахуйн нэгж нь шинээр байгуулагдсан болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулсан бол тэр хугацааны ажиллагчдын тооны дунджийг авна.

1.5.2.2 Жилийн борлуулалтын орлого-3h: Үйлдвэр, аж ахуйн нэгжийн хэмжээг тодорхойлох нэг үндсэн үзүүлэлт нь борлуулалтын орлогын хэмжээ болно. Борлуулалтын орлогын бүлэглэлт нь салбарын онцлогоос хамаарч зохицуулагдана.

1.5.2.3 Нийт хөрөнгийн хэмжээ (үзүүлэлт-3i): Санхүүгийн зуучлал, санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд хөрөнгийн хэмжээгээр бүлэглэлт (страта)-ийг ашиглан судалгаа явуулах боломжтой.

- 1.5.3 Газар зүйн байрлал (үзүүлэлт-2h):** Энэ хэсэгт засаг захиргааны хаяг, байршлын кодоос гадна тухайн нэгжийг олж болох олонд нэршиж хэвшсэн хаяг, олох боломжгүй тохиолдолд зэргэлдээх газрын хаяг зэргийг нэмэлт байдлаар тодорхойлон тусгаж болно.
- 1.5.4 Секторын ангилал:** Секторын ангиллыг аж ахуйн нэгж бүрийн хувьд үйл ажиллагааг нь харгалзан бүртгэж оруулна.
- 1.6 Ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд:** Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж болон орон нутгийн нэгжүүдийн анх үүссэн огнооноос эхлэн түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг судлах 3 хэмжигдэхүүнийг зааж өгнө.
- 1.6.1 Үүсэн байгуулагдсан огноо:**
- 1.6.1.1** Хуулийн этгээдийн хувьд хууль ёсоор үүсэн байгуулагдаж, бүртгэлийн байгууллагаас регистрийн дугаар авсан огноо (үзүүлэлт-1d)
- 1.6.1.2** Хувь хүний хувьд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог засаг захиргааны нэгж, байгууллагаас зөвшөөрөл олгосон огноо
- Статистик нэгжийн хувьд үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгжийн үйл ажиллагаагаа эхэлсэн огноо байна. (орон нутгийн нэгж-үзүүлэлт 2f), үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж -үзүүлэлт 3f)
- 1.6.2 Үйл ажиллагаагаа зогсоосон огноо:** Хуулийн эрх бүхий байгууллагаас хуулийн этгээдийн хувьд хаагдсан, татан буулгасан огноо, иргэдийн хувьд үйл ажиллагаагаа нь бүрэн зогсоосон тухай мэдэгдэл өгсөн огноо байна.
- 1.6.3 Татан буугдсан огноо:** Бүртгэх эрх бүхий байгууллагаас улсын бүртгэлийн жагсаалтад тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай бичилт хийгдсэн огноогоор хуулийн этгээд нэгжийг татан буугдсанаар бүртгэнэ. Статистик нэгжийн хувьд албан ёсны статистик мэдээллээр статистик нэгж үйл ажиллагаагаа зогсоосон огноогоор үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, орон нутгийн нэгжийн үйл ажиллагаагаа зогсоосон огноог бүртгэнэ (орон нутгийн нэгж -үзүүлэлт 2g, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж -үзүүлэлт 3g). 24 сарын туршид үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуйн нэгжийг статистикийн нэгжээс хасч болно.
- Хуулийн этгээд нь хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлэх, нэгдэх, тусгаарлаж байгуулагдах, хуваагдах тохиолдолд статистик нэгж нь шууд татан буугдахгүй байж болно. Жишээ нь: уул, уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн уурхай нь статистикийн нэг нэгж байна. Уг уурхайг эзэмшиж байсан хуулийн этгээд татан буугдаж эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тухайн уурхайг татан буулгаснаар бүртгэхгүй ба зөвхөн хуулийн этгээдийг татан буулгаж, статистик нэгжид хамаарах хуулийн этгээдийг өөрчлөн бүртгэнэ.
- 1.6.4 Бизнес регистрийн санд бүртгэсэн огноо:** Хуулийн этгээд, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж болон орон нутгийн нэгжийн хувьд регистрт бүртгэж бичилт хийгдсэн огноог бүртгэж оруулна.

БҮЛЭГ III. БИЗНЕС РЕГИСТРИЙН ХӨТЛӨЛТ

Регистрт өөрчлөлт, хөдөлгөөнийг хийхдээ албан ёсны статистик мэдээлэл болон захиргааны мэдээллийг ашиглана.

Албан ёсны статистик мэдээлэл нь статистик нэгжийн сангийн үзүүлэлтүүдийн үнэн зөв эсэхийг хянах, засварлах эх үүсвэр болно. Албан ёсны статистик мэдээлэлд бизнес регистрийн улирлын мэдээ болон эдийн засгийн салбаруудын статистик мэдээллийг хамруулах бөгөөд бизнес регистрийн улирлын мэдээ нь регистрт өөрчлөлт хийх үндсэн мэдээлэл болно. Салбаруудын жилийн эцсийн мэдээний боловсруулалт дуусаж, эцэслэснээс хойш нэг сарын дотор үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, биет болон биет бус хөрөнгийн мэдээлэлд өөрчлөлт, хөдөлгөөнийг хийнэ.

Захиргааны мэдээлэл нь бизнес регистрийн сангийн үзүүлэлтүүдийн үнэн зөв эсэхийг хянах, засварлах, шинэчлэх эх үүсвэр болно. Захиргааны статистикийн мэдээллийн дараах эх үүсвэрүүдийг бизнес регистрийн сангийн үзүүлэлтийг шалгах, засварлах, шинэчлэхэд ашиглана. Үүнд:

1. Үндэсний татварын ерөнхий газрын бүртгэлийн мэдээллийн сан:

- a. **Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг** илрүүлж, тэдгээрийг бизнес регистрийн улирлын мэдээнд хамруулж судална.
- b. **Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн санд татан буугдсан ААНБ-ыг** бизнес регистрийн санд татан буулгана. ААНБ нь шилжих хөдөлгөөнд оролцсон бол хамаарахгүй. Шилжих хөдөлгөөнд оролцсон ААНБ- тай холбогдож, тодруулсны дараа шилжин очсон байршлаар нь шилжүүлэн бүртгэнэ.
- c. **Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар төлөгчийн** мэдээллийн сангийн үзүүлэлтийг ашиглан Регистрт борлуулалтын орлогыг шинэчилнэ.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны холбоо, сан, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэлийн сан: Төрийн бус байгууллагуудын бүртгэлийн сангийн мэдээллийг ашиглан шинээр байгуулагдсан төрийн бус байгууллагуудыг илрүүлнэ. Сүм хийд, соёлын байгууллагын жилийн эцсийн судалгааны түүврийн хүрээг бодитой тодорхойлох зорилгоор шинээр байгуулагдсан холбоо, нийгэмлэг, сан, шашны байгууллага, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хуулийн этгээдээр шууд бүртгэнэ.

3. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн бүртгэлийн сан: Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, тэдгээрийн хаяг, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулагч улсыг тодорхойлох зорилгоор холбогдох мэдээллийг авч бизнес регистрийн санд өөрчлөлтийг хийнэ.

4. Санхүүгийн зохицуулах хорооны банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, брокер диллерийн компани, хувьцаат компаниудын мэдээлэл: Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, брокер диллерийн болоод хувьцаат компаниудын хаягийн болоод эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэн Регистрт өөрчлөлтийг тусгана.

5. **Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудын мэдээлэл:** Боловсрол, соёлын байгууллага /цэцэрлэг, бага, дунд, дээд сургууль, соёлын төв, эрдэм шинжилгээний байгууллагууд/-ын хаяг, эдийн засгийн үзүүлэлтийг үндэслэн Регистрт өөрчлөлтийг тусгана.
6. **Эрүүл мэндийн яамны эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл:** Эрүүл мэндийн байгууллагуудын /улсын болон хувийн эмийн сан, эмнэлэг/ хаяг, эдийн засгийн зарим үзүүлэлтийг үндэслэн Регистрт өөрчлөлтийг тусгана.
7. **Төрийн өмчийн хорооны төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мэдээлэл:** Төрийн болон орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газрууд /Эрдэнэт үйлдвэр, Монгол шуудан, Авто зам засвар, арчлалтын нэгдэл, Эмийн үйлдвэр гэх мэт ТӨҮГ болон ОНӨҮГ/-ын хаяг, өмчийн эзлэх хувь, ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, хөрөнгийн үзүүлэлтийг үндэслэн Регистрт өөрчлөлтийг тусгана.
8. **Сангийн яамны төрийн болон төсөвт байгууллагуудын мэдээлэл:** Төрийн болон төсөвт байгууллагуудын байршил, ажиллагчдын тоо, санхүүжилтийн хэмжээг авч Регистрт өөрчлөлтийг хийнэ.
9. **Монгол банкны арилжааны банкны мэдээлэл:** Монгол банк болон арилжааны банк, тэдгээрийн салбар нэгжүүдийн хаяг, эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийг ашиглан Регистрийн үзүүлэлтийг шинэчилнэ.
10. **Улсын дээд шүүхийн улс төрийн намын мэдээлэл:** Улс төрийн намын бүртгэлийн санг авч шинээр байгуулагдсан улс төрийн намыг илрүүлж, бизнес регистрийн санд нэмэлт хөдөлгөөн хийнэ.

Дээрх албан ёсны статистик мэдээлэл болон захиргааны мэдээллийг уялдуулахын тулд 2 ялгах дугаар (регистрийн дугаар)-ыг хэрэглэж болно.

Регистрт бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны төрөл, хэлбэр өөрчлөгдөх, бусад аж ахуйн нэгжтэй нэгдэх, татан буугдах зэрэг ердийн хөдөлгөөний өөрчлөлтийг нэгдсэн ойлголт, тодорхойлолтын дагуу тогтмол хийнэ.

Регистрт мэдээллийн өөрчлөлтийг хийхдээ дараах 4 шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

- **Нэгдүгээрт**, “Шинээр нэмэгдэж байгаа” аж ахуйн нэгж, байгууллагыг регистрт бүртгэх хугацаа, хамралтад хяналт тавьсан байна. Тухайн жилд байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 95% нь байгуулагдсаныхаа дараагийн (n+1) жилд регистрийн санд заавал бүртгэгдсэн байна.
- **Хоёрдугаарт**, Давхар бүртгэлээс зайлсхийнэ. Статистик нэгжийг давхар бүртгэх нь түүвэр судалгааны үр дүнд муугаар нөлөөлж, судалгааны үр дүнг тархаахад хүндрэл учруулдаг. Иймд регистрт бүртгэгдсэн нэгжүүдийн давхардлыг шалгаж байх ёстой.
- **Гуравдугаарт**, Үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуйн нэгжүүдийг тусгайлан авч үзсэн байна. Регистрт бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаагаа зогсоосон, татан буугдахаар хүлээгдэж байгаа зэрэг үйл ажиллагаа нь идэвхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийг системтэйгээр илрүүлж тогтоож байх шаардлагатай. Идэвхгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа ААНБ регистрийн санд бүртгэлтэй байх нь ААНБ-ын талаарх үзүүлэлтийн динамик бүрдүүлэхэд хүндрэл үүсгэдэг.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүлэг тус бүр дэх идэвхгүй нэгжүүд нь нийт нэгжүүдийн тооноос 2 дахин бага байвал зохино.

- **Дөрөвдүгээрт**, Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, секторын ангиллыг үнэн зөв тодорхойлсон байна. Эдгээр үзүүлэлтүүд нь статистикийн түүвэр судалгааны түүврийн хүрээг үнэн бодитой тогтооход нөлөөлдөг. Түүврийн хүрээг тогтооход шаардагдах хувьсагч үзүүлэлтүүдийг (ажиллагчдын тоо, үйл ажиллагааны чиглэл, борлуулалтын орлого гэх мэт) тогтмол шинэчилж, шалгаж байх шаардлагатай. Түүвэр судалгаанд хамрагдсан нэгжүүдийг жилд нэг удаа, үлдсэн нэгжүүдийг доод тал нь 2 жил тутам шинэчилж байвал зохино. Яам, агентлагаас гаргадаг захиргааны статистик мэдээллийг ашиглан хагас жил тутам ажиллагчдын тооны мэдээллийг шинэчилж байх шаардлагатай.

Регистрийн түүхийн сан

Регистрт бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр өөрчлөлт, хөдөлгөөнийг архивласан түүхийн сан байдлаар зайлшгүй хадгалах шаардлагатай. Регистрт бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон бусад үзүүлэлтүүдийн өөрчлөлт хөдөлгөөн нь аж ахуйн нэгж, байгууллагын үүсэл хөгжлийг харуулах бөгөөд эдгээр үзүүлэлтийг түүхийн санд хадгална. Мөн тайлант жилийн эцэст регистрийн мэдээллийг архивлан хадгалах ёстой.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн өмчит хуулийн этгээд	Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээд
Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Хамтарсан үйлдвэр	Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээд Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж байгуулсан нэгж
Төвлөрсөн төсөвт байгууллага Орон нутгийн төсөвт байгууллага Төрийн бус байгууллага	Улсын төсвөөс санхүүждэг байгууллагууд Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд Иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг ойлгоно. (Төрийн бус байгууллагын тухай хууль. 4 дүгээр зүйлийн 1 дэхь заалт)
Нам	Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл .("Улс төрийн намын тухай" Монгол улсын хуулийн)
Сан	Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээд. (Монгол улсын "Иргэний хууль"-ийн 36 дугаар зүйлийн 2 дахь заалт)
Хоршоо	Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээд
Шашны байгууллага	Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, цуглаан, төв болон тэдгээрийн удирдах байгууллага
Хараат компани	Компаний нийт энгийн хувьцааны 20-51 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа

Охин компани	Компаний нийт энгийн хувьцааны 51-ээс 100 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээд
Компаний салбар	Толгой компаний оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж
Үйл ажиллагаагаа түр зогсоосон	1 жил 6 сараас доош хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаагаа явуулах зорилго бүхий аж ахуйн нэгж
Үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон	1 жил 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй, тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн аж ахуйн нэгж
Татан буугдсан	Дампуурсан, хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн, үйл ажиллагаа явуулах зөвшөөрсөн хугацаа нь дууссан, зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан, нэг ч гишүүнгүй болсон зэрэг үндэслэлүүдээр шүүх татан буулгах шийдвэрийг гаргасан;
Нийлүүлсэн	Хоёр буюу хэд хэдэн компаний үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон компанид шилжүүлснийг;
Нэгдсэн	Компаний үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлснийг;
Хуваасан	Компаний үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх 2 буюу түүнээс дээш компанид бүрэн шилжүүлснийг;
Тусгаарласан	Компаний үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлснийг;
Өөрчлөгдсөн	Хувьцаат компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаат компани болох замаар өөрчлөгдсөнийг;
Борлуулалтын орлого	Барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэсний орлого
Биет хөрөнгө	Орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил, машин, тоног төхөөрөмж болон өсөж үрждэг хөрөнгө
Биет бус хөрөнгө	Биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгө

**Олон үйл ажиллагаатай нэгжийн үндсэн
үйл ажиллагааг зөв тодорхойлох нь**

Салбар	Дэд салбар	Дэд бүлэг	Тодорхойлолт	Хувь
D	28	2811	Барилгын зориулалттай төмөр хийц хэсгийн үйлдвэрлэл	7%
	15	1511	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хадгалалт, өлөн гэдэс боловсруулалт	8%
		1520	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3%
		1531	Үр тарианы гурил үйлдвэрлэл	21%
		1533	Малын тэжээл үйлдвэрлэл	8%
	21	2102	Цаасан уут, сав үйлдвэрлэл	5%
G	51	5220	Хүнс, ундаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	7%
		5211	Хүнс, ундаа, тамхи голлосон төрөлжсөн бус барааны дэлгүүр	28%
K	74	7421	Барилгын зураг төсөл, геологи хайгуулын ажиллагаа	13%

Салбарыг тодорхойлох	Салбар D - Боловсруулах үйлдвэрлэл		52%
	Салбар G - Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоцикл, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа		35%
	Салбар K - Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа		13%
Дэд салбарыг тодорхойлох	Дэд салбар 28 - Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл		7%
	Дэд салбар 15 - Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт		40%
	Дэд салбар 21 - Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл		5%
Бүлгийг тодорхойлох	Бүлэг 15.1 - Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт		8%
	Бүлэг 15.2 - Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл		3%
	Бүлэг 15.3 - Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл		29%
Дэд бүлэг тодорхойлох	Дэд бүлэг 1531 - Үр тарианы гурил үйлдвэрлэл		21%
	Дэд бүлэг 1533 - Малын тэжээл үйлдвэрлэл		8%
	Хүнс, ундаа, тамхи голлосон төрөлжсөн бус барааны дэлгүүр - 5211 нь их хувь эзэлж байгаа хэдий ч « Үр тарианы гурил үйлдвэрлэл » буюу 1531 нь үндсэн үйл ажиллагаа болно.		
	Хэрэв үндсэн үйл ажиллагааг хамгийн их хувь эзэлж байгаагаар авахад боловсруулах үйлдвэрлэлээр үйл ажиллагааг тогтоож болохгүй юм.		